

БОЛОВСРОЛД СУУРИЛСАН АМЬДРАЛЫН ЧАНАРЫН ЗАГВАР

Лига Марина Борисовна, профессор, БЧУИС ОХУ, Чита хот

Боловсрол ба амьдралын чанарын тухай ойлголт харилцан нягт уялдаа холбоотой.

Амьдралын чанар нь, нэг талаас, бие хүн ба нийгмийн амьдралын хэрэгцээг хангах хэрэгсэл ба, нөгөө талаас, боловсролын өнөөгийн байдлын үзүүлэлт юм. Боловсрол нь тухайн нийгмийн нийгэм- соёлын чадамжид нийцсэн амьдралын зохих ёсны түшинд хүрэхэд шаардагдах төрөл бүрийн механизм, хэрэгслийг өөртөө багтаадаг нарийн төвөгтэй, олон талт, олон шатлалтай тогтолцоо юм. XX зууны төгсгөл, XXI зууны эхэн үеэр шинжлэх ухаан, улс төр, өдөр дутмын хэллэгт “амьдралын чанар” гэсэн шинэ ойлголт гарч ирсэн билээ.

Амьдралын чанарын зарчим төлөвших үе шатыг судлаач дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. «эмбриональный» буюу эхний үе (1950-иад оны төгсгөл- 1960 он).
2. «квантификационный» буюу бүрэлдэх үе (1960- 1970 он).
3. «концептуальный» буюу ойлголт болж төлөвших үе (1970-1990 он).
4. «информационный» буюу мэдээллийн үе (1990-оноос одоог хүртэл).

Амьдралын чанарын зарчим төлөвших эхэн үед энэ ойлголт дөнгөж хэлбэршиж эхлэх ба нэр хүндтэй хэвлэлд сурталчилгааны зорилгоор, сонгуулийн кампанит ажлын үеэр ихэвчлэн ашиглагддаг байжээ. Амьдралын чанарын үндсэн үзүүлэлт нь нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ байв. Материаллаг баялаг давамгайлсан нийгмээс хүний оюуны хэрэгцээг хангах нийгэмд шилжих нь энэ үеийн амьдралын чанарын зорилго байсан гэж ойлгож болно.

Хоёрдугаар шат буюу тус зарчим бүрэлдэх үед нийгмийн үзүүлэлт, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулжээ. 1960 оны төгсгөл, 1970-аад оны эхэн үед АНУ-ын Хүмүүнлэгийн шинжлэх ухааны академийн комисс Д.Беллийн удирдлагаар нийгэм, олон нийтийн дунд зохион байгуулж байгаа арга хэмжээний ашиг, алдагдлыг үнэлэх зорилготой “Нийгмийн тооцооны систем”-ийг боловсруулсан байна. Мөн Д.Белл үнэлгээ хийхийн тулд нийгмийн шалгуур үзүүлэлтийн систем боловсруулах зайлшгүй шаардлагатай салбаруудыг тодорхойлсон байдаг.

Джон Форрестерийн Мир-1, Мир-2 гэж нэрлэсэн дэлхийн загварыг санал болгосон “Мировая динамика” бүтээл хэвлэгдэн гарсныг гуравдугаар шатны эхэн үе гэж тооцдог. Энэ бүтээлд амьдралын чанарын тухай ойлголтыг орчин үеийн томоохон асуудал талаас нь авч үзсэн байдаг. Энэ шатанд Ромын клубын үйл ажиллагаанд тусгалаа олсон “дэлхийн загварчлал”, “амьдралын субъектив чанар” буюу “амьдралын мөн чанар” гэсэн амьдралын чанарын тухай ойлголтыг судлах хоёр үндсэн чиглэл гарч ирсэнтэй холбоотой амьдралын чанар нь ойлголт болж төлөвшдөг.

Тасралтгүй боловсорч, мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай оюуны чадамжаа тодорхой түвшинд байлгасны үндсэн дээр хувь хүний амьдралын эрхэм чанар хангагдана. Мэргэжлээрээ хөрвөх, өөрөө суралцах, өөрийгөө боловсруулах, хөгжүүлэх зэргийг амьдралын эрхэм чанарт хүрэх боломж олгодог бие хүнд зайлшгүй байх чанар гэж үздэг.

Амьдралын эрхэм чанарыг хангахын тулд хувь хүн боловсролоор дамжуулан байнга хувьсан өөрчлөгдөж байдаг нийгэмд ажиллаж амьдрахад хэрэгтэй өндөр түвшний хүмүүжил, соёл, бие хүний чанар (зохион байгуулах, бие дааж шийдвэр гаргах, өөрийн үйлдэлд хариуцлага хүлээх чадвар)-ууд, бүтээлч зорилтыг шийдвэрлэх боломж олгодог мэргэжлийн өндөр ур чадвар эзэмших хэрэгтэй. Боловсролын чанарын ба түвшний өсөлт улс орны нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулахад, амьдралын эрхэм чанарыг хангахад тус дөхөм болно.

Амьдралын чанарын боловсролд тулгуурласан загвар нь дараах үндсэн шинжтэй байна. Үүнд:

1. Онолын мэдлэгийн гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөн, түүнийг шинэ мэдлэг бүтээх эх үүсвэр болгох ба нийгмийн бүхий л салбарын амьдрал үйл ажиллагаанд ашиглах;
2. Мэдээлэл ба мэдлэг нь шинэ үйлдвэрлэх хүчин болсноор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэгээс үйлчилгээ үзүүлэх хэлбэрт шилжих;
3. Боловсролын ач холбогдол нэмэгдэж мэдлэг, мэдээллийг үйлдвэрлэдэг анги давхрага шинээр төрөн гарч, эрх мэдэл нь оюунлаг, өндөр боловсролтой хүмүүст

- шилжих;
4. Ажил эрхлэлтийн бүтэц, мэргэжил сонголт, хэрэгцээ, үнэт зүйлс, сэдэлжилт өөрчлөгдөж, нийгмийн ялгаралд материаллаг өмч биш, мэдлэг боловсрол шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх;
 5. Нийгмийн давхрага үүсэхэд анги давхрагын бүтцээс мэргэжил эзэмшилтийн бүтэц илүү ач холбогдолтой болох;

Мэдлэг боловсролтой хүний загвар нь мэдлэгт суурилсан нийгмийн гол нөөц хүчин байна. Мэдээллийн процессын нөлөөгөөр эдийн засгийн бүтцэд өөрчлөлт гарна. К.Кларкийн “1940 оны үеийн эдийн засгийн дэвшлийн нөхцөл байдал”, Ж.Фурастье -ийн “Великая надежда” зэрэг бүтээлд эдийн засгийн дараах гурван секторыг онцолсон байдаг:

1. Аж үйлдвэрийн олборлох салбар, хөдөө аж ахуй;
2. Аж үйлдвэрийн боловсруулах салбар, барилга, хот байгуулалт;
3. Төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх салбар;

Хүний хэрэгцээг хангахад чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, соёл, нийгмийн хангамж зэрэг нийгмийн үйл ажиллагааны олон салбарыг хамарсан гуравдахь секторын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж эхний хоёр секторын гүйцэтгэх үүрэг буурч байна.

Түүнчлэн 21-р зууны эхээр технологи өндөр хөгжсөн салбараар төлөөлүүлсэн (худалдаа, санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө) мэдээлэл, мэдлэг үйлдвэрлэдэг 4 дэх сектор бий болжээ. Сүүлийн үед сэдэл төлөвшүүлж, амьдралын утга учрыг ойлгуулах, хувийн, мэргэжлийн, ажил хэргийн чанартай ба төрийн удирдлагын түвшний үйлчилгээг хэвшүүлэх 5 дахь сектор бүрэлдэх процесс явагдаж байна. Мэдээллийн үйлдвэрлэлд тулгуурласан дөрөв ба тав дахь секторын салбарууд тэргүүлэх ач холбогдолтой болно.

Нэмүү өртгийн үндсэн эх үүсвэр нь хөрөнгийн бус, харин оюуны капиталыг амьдралд хэрэгжүүлэх мэдлэг чадварыг эзэмшсэн хүн байх ёстой гэж үзсэн удирдлагын шинэ загвар бий болж байгаа ажээ. Орчин үеийн нийгмийг удирдах нь хүнийг удирдана гэсэн үг юм.

Амьдралын эрхэм чанарыг хангаж, баялаг бүтээхэд хэрэглэгдэх мэдлэг, мэдээлэл, туршлага, зохион байгуулах боломж, мэдээллийн суваг зэргийг оюуны капитал гэнэ. Хүмүүн капитал ба биет бус капиталын цогц нэгдэл нь оюуны капитал юм.

Мэдлэг боловсролтой хүний загвар бий болгохын тулд боловсролын тогтолцоог бүхэлд нь шинэчлэх шаардлага тулгарч байна. Цаашдаа

уншиж чаддаггүй хүнийг биш, уншихад суралцаагүй хүнийг эрдэм боловсролгүй хүн гэж үзэх болно. Д.Белл мэдлэгийг хамтын бүтээгдэхүүн, Г.Стюарт мэдлэгийг нийгмийн баялаг гэж нэрлэсэн байдаг. Боловсрол нийгмийн үнэт зүйл болж, мэдлэг бэлэгдлийн шинжтэй капитал болсон, боловсролд суурилсан нийгмийг орчин үеийн нийгэм гэнэ. Мэдлэг нь капиталын шинэ хэлбэр болохын хувьд бусад төрлийн баялгаас ялгаатай:

1. Мэдлэг хүртээмжтэй.
2. Мэдлэг баялагийн эх булаг болохын хувьд дуусашгүй, дундаршгүй.
3. Мэдлэг тухайн хүний амьдарлын нөхцөл, авьяас чадвараас биш, хувь хүн мэдлэгийг хэрхэн хэрэглэж байгаагаас шалтгаалдаг. Мэдлэгийг хувь хүнээс салгаж авах боломжгүй.
4. Мэдлэг нь шинэ мэдлэг үйлдвэрлэх үндэс болдог. Мэдлэг мэдээлэл нь аж үйлдвэржилтийн дараах нийгэмд зөвхөн үнэт зүйл биш бөгөөд бүтээгдэхүүнд агуулагддаг өөрийн өртгийг бий болгодогт анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж зарим судлаач үздэг. Мэдлэгийн тусламжтай бий болсон өөрийн өртөг нь тухайн бүтээгдэхүүний үнэ цэнэ нь болдог. Үйлдвэрлэлийн явцад мэдлэг устаж үгүй болдоггүй, харин бүтээгдэхүүн болж хувирдаг. Мэдлэг нь шинэ бүтээгдэхүүн, шинэ технологи, хүний шинээр эзэмшсэн дадал чадвар, үйлдвэрлэгч ба хэрэглэгчдийн шинэ харилцаанд биеллээ олдог.

5. Мэдлэг нь капитал болохын хувьд зөвхөн мэдлэгийг эзэмшиж байгаа хүнд биш, нийт хүн төрөлхтөнд үйлчилдэг.

Нийгмийн хөгжилд мэдлэгийн нэн тэргүүний ач холбогдлыг мерикратия буюу оюунлаг хүмүүсээс бүрдсэн нийгмийн шинэ давхрага үүсэж байгаа нь баталж байна. Шинэ давхрагын онцлог нь өндөр боловсрол, чинээлэг, хангалуун амьдрал, техник технологи өндөр хөгжсөн аж ахуйн салбарт ажил эрхлэх, мэдлэг, мэдээллийг тэргүүлэх чиглэлээ болгож тэдгээрийг бүтээлчээр хэрэглэх, өөрийн бүтээлч төлөвлөгөө, санааг хэрэгжүүлэх, нийгэм, хамт олон дунд биеэ авч явах чадвар, өөрийгөө боловсруулах эрмэлзлэл зэргээр тодорхойлогдоно. Материаллаг бус үнэт зүйлсийн тухай ойлголт нь хүний материаллаг сэдэлжилт үгүй болдоггүй, зөвхөн түүний тэргүүлэх ач холбогдол нь өөрчлөгддөг гэдгийг тэмдэглэн хэлэх боломж олгож байна.

Шинэ нийгэмд амьдарч байгаа материаллаг бус эд зүйлсийг дээдэлдэг хүн эдийн засгийн хүчин зүйлийн ач холбогдлыг үгүйсгэдэггүй ч, өөрийгөө илэрхийлэх, өөрийн хүсэл зорилгоо биелүүлэхэд

илүү анхаарч, амьдралд сэтгэл хангалуун, өндөр боловсрол эзшихэд тэмүүлж, улс төрийн сэдвээр маргалдах сонирхолтой, бүтээлчээр ажиллах хүсэл тэмүүлэлтэй байдаг.

Материаллаг бус үнэт зүйлс нь хүн бүрийн тайван, сайхан амьдрал хангагдсан, эсвэл эдийн засгийн аюулгүй байдал мэдрэгдсэн тохиолдолд ач холбогдолтой болдог.

Амьдарлын чанар, материаллаг байдал, боловсрол, хувь хүний аюулгүй байдал, нийгэм хамгаалал өндөр түвшинд хүрсэн нөхцөлд л материаллаг бус үнэт зүйлс бодит байдал болж хувирна.

ДҮГНЭЛТ

1. Нийгмийн хөгжлийг тодорхойлох хүчин зүйл нь мэдлэг байх болно. Эдийн засгийн ба нийгмийн гүйцэтгэх үүрэг мэдээлэлд шилжинэ. Орчин үеийн мэргэжилтэн бэлтгэх, мэдлэг үйлдвэрлэх, хадгалах, боловсруулах төв болсон их сургуулиуд нийгмийн тэргүүлэх байгууллага байна.
2. Нийгэмд анги давхрагын ялгарал үүсэхэд хувийн өмч бус, мэдлэгийн түвшин шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Нийгэмд анги давхрага үүсгэх гол үндэс нь мэргэжлийн бүтэц байна.
3. Аж үйлдвэржилтийн дараах эдийн засаг нь үйлдвэрлэгч бус, үйлчлэх эдийн засаг болж хувирна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бек, У. (2000). Общесво риска. На пути к другому модерну / Пер. с нем. В. Седелькина и Федоровой, Н., Послес, А. Филлипова. Москва. Прогресс-Традиция
- Дракер, П. (1999). Посткапиталистическое общество. Новая постиндустриальная волна на Западе. Антология / под редакцией В.Л. Иноземцова. – Москва. Academia, 67-101
- Тоффлер, Э. (2004). Шок будущего: Пер. С англ. / Э. Тоффлер. –М., ООО “Издательство АСТ”

*Орчуулсан: Ц.Цэцэгмаа, магистр, НХУС
Ц.Эрдэнэчимэг, магистр, НХУС*